



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/701

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 , Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 88 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “COVID-19”-ын цар тахлын тархалтыг бууруулах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор сумдад нэгдсэн шинжилгээ авах сумдын “Нэг цэгийн үйлчилгээ”-ний бэлтгэл бэлэн байдлыг хангахад зориулан түргэвчилсэн төстийн шинжилгээний оношлуур худалдан авах санхүүжилтэнд 120000.0 мянган төгрөг /нэг зуун хорин сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 120000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 2460
D/Zah-A/701-Bo

Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн
А/701 дүгээр захирамжийн хавсралт



СУМДЫН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ БЭЛТГЭЛ
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТҮРГЭВЧИЛСЭН ТЕСТИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОШЛУУР ХУДАЛДАН АВАХ САНХҮҮЖИЛТ

№	Хүлээн авах байгууллагын нэр	Нийлүүлэх байгууллагын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн /мянган төгрөг/
1.	Аймгийн Онцгой байдлын газар	“Акютест” ХХК №02 гэрээ	10000	12000.00	120000.0
Нийт дүн			10000		120000.0

-оОо-